



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

НИЙГЭМ СУДЛАЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ADB ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

НИЙГЭМ СУДЛАЛ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ	2
----------------------------	---

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. “Нийгэм судлал хичээлээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулахад баримталсан арга зүй, холбогдох тулгуур ойлголт, нэр томъёоны тайлбар	5
1.1. Сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтуудын шинжилгээ.....	5
1.2. Үнэлгээний нэгжийн төлөвлөлт.....	6
1.3. Үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүн	7
1.4. Шалгуур, гүйцэтгэлийн түвшин	9
1.5. Жилийн суралцахуйн үр дүн.....	11
1.6. Нэр томъёоны тайлбар, тодорхойлолт.....	12
Хоёр. Суурь, бүрэн дунд боловсролын нийгэм судлал хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж	15
2.1. Үнэлгээний төлөвлөлт	16
2.1.1 Нэгжийн үнэлгээний төлөвлөлт	16
2.1.2 Үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөлт	17
2.2. Үнэлгээний хэлбэр	18
2.2.1 Явцын үнэлгээ хийх арга зүй (явцын үнэлгээ хийхдээ нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал).....	19
2.2.2 Үр дүнгийн үнэлгээ хийх арга зүй	30
2.3. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар	32
2.3.1 Жишиг даалгаврын жишээ, хэрэглэх аргачлал	32

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. “Нийгэм судлал хичээлээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулахад баримталсан арга зүй, холбогдох тулгуур ойлголт, нэр томъёоны тайлбар

Та бүхний гар дээр очиж буй “Нийгэм судлал хичээлээр сурагчдын хүрэх суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур”-ыг хэрхэн хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргэж байна. Энэхүү зөвлөмж нь хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэхэд багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Багш та бүхэн шалгуурыг боловсруулахад баримталсан арга зүй, холбогдох тулгуур ойлголт, нэр томъёотой сайтар танилцах нь уг шалгуурыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь үндэс болох юм.

Шалгуурыг боловсруулахад баримталсан арга зүй, зарчим нь:

1. Сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтуудыг задлан шинжлэх
2. Үнэлгээний нэгжийг төлөвлөх
3. Үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүн (СҮД) г тодорхойлох
4. Шалгуур, гүйцэтгэлийн түвшин боловсруулах
5. Жилийн суралцахуйн үр дүнг боловсруулах

1.1 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ДЭХ СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТУУДЫН ШИНЖИЛГЭЭ

Суралцахуйн зорилт (learning objectives), түүнийг шинжлэх:

Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилт(агуулга)-ыг дараах шаардлагын дагуу шинжилсэн.

1. Суралцахуйн зорилтын SMART буюу ухаалаг байх шаардлага:
 - Specific- S Тусгай
 - Measureable-М Хэмжигдэхүйц\ажиглагдахуйц байх
 - Attainable-А Цаг хугацаандаа тохирохуйц нөхцөлтэй байх
 - Relevant-А Хамааралтай, үр дүнд хүрсэн байх
 - Time Based-Т Сурагч төвтэй, суралцахуйн түвшинд тохирсон байх

2. Суралцахуйн зорилтын томъёололд тавих шаардлага:

- Төрх байдал (behavior) буюу гүйцэтгэл (Performance)
Сурагчид юуг хийх эсвэл бүтээх чадвартай болох вэ?, (үйл, үйлдэл, агуулга, үзэл баримтлалыг багтаана. Хэмжигдэхүйц үйл үгээр илэрхийлнэ.)
- Нөхцөл (Conditions)
Мэдлэг, чадвар эсвэл компетенцийг хэрхэн харуулах вэ? (Юун дээр ур чадвараа харуулах, ур чадвараа харуулах багаж хэрэгсэл, эх сурвалж, нөөц г.м)
- Шалгуур (Criteria)
Ямар шалгуураар сурагчийн эзэмшсэн тухайн мэдлэг, чадварыг харуулах вэ? (Ямар аргаар, арга замаар, онол, загвараар харуулах гэх мэт)

Нийгэм судлал хичээлийн сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтад тавигдах шаардлагын дагуу шинжилгээ хийсэн болно. Энэхүү зөвлөмжийн хүрээнд та бүхэнд цэгцтэй ойлголт өгөх үүднээс суурь боловсролын 9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”, бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” агуулгыг сонгон авч, тус бүр нэг суралцахуйн зорилтыг шаардлагын дагуу хэрхэн шинжилсэнийг жишээ болгон үзүүлэв. Суралцахуйн зорилтад хийсэн шинжилгээ нь та бүхэнд очиж буй шалгуурыг боловсруулах ажлын эхлэл үе шат байсан юм.

Жишээ-1.1

9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”

№	Суралцахуйн зорилт	Гүйцэтгэл	Нөхцөл	Шалгуур
1	9.5в. Улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг харьцуулан судалж, ардчилалд иргэдийн оролцоо ямар ач холбогдолтойг тайлбарлах	Улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг харьцуулан судлах	Иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгаа	Ардчилалд иргэдийн оролцоо ямар ач холбогдолтойг тайлбарлах

Жишээ-1.2

10-р ангийн “Улс төр”

№	Суралцахуйн зорилт	Гүйцэтгэл	Нөхцөл	Шалгуур
1	10.126. Монгол улсад ардчиллын тулгуур үнэт зүйлс хэрхэн хэрэгжиж байгааг судалгааны эх сурвалж, баримт жишээнд үндэслэн дүгнэлт хийх	Монгол улсад ардчиллын тулгуур үнэт зүйлс хэрхэн хэрэгжиж байгааг судлах	Ардчиллын тулгуур үнэт зүйлс	Судалгааны эх сурвалж, баримт жишээнд үндэслэн дүгнэлт хийх

1.2 ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Суралцахуйн зорилтад шинжилгээ хийсний дараагаар агуулгыг үнэлгээний нэгжид хуваан төлөвлөх ажил хийгдсэн. Үнэлгээний нэгжид хуваан төлөвлөхдөө дараах зарчмыг баримталсан.

- Нэг улиралд 1-2 нэгж байхаар төлөвлөсөн.
- Нэг бүлэг агуулгыг дотор нь хувааж нэгжлэх нь судлагдахууны онцлогоос шалтгаалж тохиромжгүй байгаа тул бүлэг тус бүрийг нэг үнэлгээний нэгж гэж үзсэн.
- Сургалтын хөтөлбөрөөс суралцахуйн зорилтыг багцлан суурь боловсролын түвшинд 5, бүрэн дунд боловсролын түвшинд 6 нэгжид бүлэглэсэн.
- Сургалтын төвлөгөөн дэх судлах цаг, сэдвийн багтаамжийг тооцсон.

Суурь боловсролын 9-р анги, бүрэн дунд боловсролын 10-р ангийг үнэлгээний нэгжид хэрхэн хуваан төлөвлөснийг жишээ болгон үзүүлэв. Үнэлгээний нэгжид хуваан төлөвлөх нь та бүхэнд очиж буй шалгуурыг боловсруулах ажлын хоёрдахь үе шат байсан юм.

Жишээ-2.1

9-р анги

№	Суралцахуйн зорилтын код	Үнэлгээний нэгж
1	9.1 а, 9.1 б, 9.1 в	Хувь хүн ба нийгэм
2	9.2 а, 9.2 б	Хувь хүн ба соёл
3	9.3 а, 9.3 б, 9.3 в	Хувь хүн ба эдийн засаг
4	9.4 а, 9.4 б, 9.4 в	Хувь хүн ба хууль
5	9.5 а, 9.5 б, 9.5 в	Нийтийн удирдлага

Жишээ-2.2

10-р анги

№	Суралцахуйн зорилтын код	Үнэлгээний нэгж
1	10.1а, 10.1б, 10.1в, 10.2а, 10.2б, 10.2в, 10.2г, 10.3а, 10.3б, 10.3в	Нийгэм, нийгмийн харилцаа
2	10.4а, 10.4б, 10.4в, 10.5а, 10.5б, 10.5в, 10.5г	Соёл
3	10.6а, 10.6б, 10.6в, 10.7а, 10.7б, 10.7в, 10.7г, 10.8а, 10.8б, 10.8в	Эрх зүй
4	10.9а, 10.9б, 10.9в, 10.10а, 10.10б, 10.10в, 10.11а, 10.11б, 10.11в	Эдийн засаг
5	10.12а, 10.12б, 10.12в, 10.13а, 10.13б, 10.13в	Улс төр
6	10.14а, 10.14б, 10.14в, 10.15а, 10.15б, 10.15в, 10.16а, 10.16б	Олон улсын харилцаа

1.3 ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН (СҮД)

Суралцахуйн зорилтад шинжилгээ хийж, үнэлгээний нэгжийг хуваан төлөвлөсний дараагаар үнэлгээний нэгж тус бүрээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн (СҮД)-г томъёолох ажил хийгдсэн.

Суралцахуйн үр дүн нь:

- Өргөн хүрээний концепцийн мэдлэг, тусгай болон ерөнхий чадварыг тусгадаг.
- Хамгийн чухал мэдлэг, чадвар, хандлагыг тусгадаг.
- Суралцахуйн туршлагын үр дүнд анхаарал хандуулах боломжийг өгдөг.
- Суралцахуйн туршлагын хүссэн үр дүнг тусгахаас биш үйл явцыг авч үзэхгүй.
- Хөтөлбөрийг амжилттай дуусгахад олж авсан байх ёстой минимум гүйцэтгэлийг үзүүлдэг.

Суралцахуйн үр дүн (СҮД)-г томъёолохдоо:

- Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хичээлийг амжилттай дуусгахад, хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай суралцахуйн амжилтыг тодорхойлох тусгай илэрхийлэл болохыг баримталсан.
- Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн нэгжийн агуулгыг судалж дууссаны дараа найдвартайгаар харуулж чаддаг болох ёстой тусгай төрх байдал (behaviours), чухал ач холбогдолтой суралцахуйг тооцсон.
- Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрөөр суралцаж дүүргэсний дараа сурагчийн хүлээсэн мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагад чиглэсэн байх ёстойг харгалзан боловсруулсан.
- Аль болох ерөнхийлсөн олон талт мэдлэг, чадварыг харуулсан байхаар томъёолсон.
- Суурь боловсролын түвшинд нэг нэгжийн хүрээнд агуулга дахь суралцахуйн зорилтыг багцалж 1-3 хүртэлх суралцахуйн үр дүнг тодорхойлсон.
- Мөн суралцахуйн үр дүн smart (ТТ) байх ёстойг харгалзсан.
- Speak to the learner – Сурагч юу мэддэг, чаддаг байх ёстойг тусгасан байх
 - Measurable – Хэмжигдэхүйц, ажиглагдахуйц, суралцахуйг хэрхэн үнэлэх тухай

- Applicable – Тухайн түвшинд сурагч эзэмшиж чадахуйц, сургалтын зорилготой тохирсон байх, эзэмшсэн мэдлэг, чадвараа хэрэглэх арга замыг тусгах
- Realistic – Сурагч, хичээл, хөтөлбөр, боловсролын түвшинтэй хамааралтай байх, сурагч СҮД-д тусгасан мэдлэг, чадварыг эзэмшсэн харуулах чадвартай байх
- Time-bound or can be completed in the time given – төлөвлөсөн хугацаанд бүрэн эзэмшиж чадахуйц байх
- Transparent – Ил тод, сурагчид шууд ойлгогдохоор байх
- Transferable – Хөрвөдөг байх, сурагч мэдлэг чадвараа олон төрлийн контекст дээр хэрэглэх боломжтой байх

Суралцахуйн үр дүнг боловсруулахдаа “ABCD” аргыг ашигласан.

A	Сонсогч / Audience	Хэн	СҮД хэнд хандсан бэ?
B	Төрх байдал / Behaviour	Юу	Сурагчид юуг мэддэг, чаддаг болно гэж хүлээж байна вэ? Идэвхтэй үйл үгээр илэрхийлнэ
C	Нөхцөл / Condition	Хэрхэн	Ямар нөхцөлд байдал, хязгаарлалтад сургалтыг явуулах вэ?
D	Degree	Хэр зэрэг	Төрх байдлыг хэр зэрэг / хэр сайн / ямар түвшинд гүйцэтгэсэн байх вэ?

Суурь боловсролын 9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”, бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” бүлэг агуулгын СҮД-ийг жишээ болгон үзүүлэв. СҮД-ийг томъёолох нь хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсруулах ажлын гуравдахь үе шат байсан юм.

Жишээ-3.1

9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”

№	Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр	Нэгж /unit assessment/	Суралцахуйн үр дүн
5	9.5а. УИХ, Засгийн газар, шүүхийн байгууллагын эрх хэмжээ, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлог, уялдаа холбоог судлах, эрх мэдэл хуваарилалт гэж юу болохыг тодорхойлох	Хувь хүн ба нийтийн удирдлага	Сурагч УИХ, Засгийн газар, шүүхийн эрх хэмжээг танилцуулсаны үндсэн дээр үндэсний түвшинд шийдвэр яаж гардаг, түүнд иргэд хэрхэн оролцож болохыг тайлбарлаж чаддаг болно.
	9.5б. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжуудыг судлах, оролцох шаардлагын үндэслэл дэвшүүлэх		Сурагч эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр, иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж гэсэн хоёр үзүүлэлтээр ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлж чаддаг болно.
	9.5в. Улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг харьцуулан судалж, ардчилалд иргэдийн оролцоо ямар ач холбогдолтойг тайлбарлах		

Жишээ-3.2

10-р ангийн “Улс төр”

№	Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр	Нэгж /unit assessment/	Суралцахуйн үр дүн
5	10.12а. Ардчиллын тулгуур үнэт зүйлсийг Монгол улсын Үндсэн хуулин дахь иргэний эрх, үүрэг, хариуцлагын тухай үзэл баримтлалтай холбон тодорхойлох	Улс төр (Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлс, Төрийн эрх мэдэл хуваарилалт ба засгийн газрын үйл ажиллагаа)	Сурагч өөрийн улсын жишээнд үндэслэн ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тайлбарлаж, хэрэгжилтийг дүгнэж чаддаг болно.
	10.12б. Монгол улсад ардчиллын тулгуур үнэт зүйлс хэрхэн хэрэгжиж байгааг судалгааны эх сурвалж, баримт жишээнд үндэслэн дүгнэлт хийх		
	10.12в. Эх сурвалжийг судлан, ардчиллын үнэт зүйлсийн хэрэгжилтийн талаар дүгнэх		Сурагч өөрийн улсын жишээнд үндэслэн төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, гүйцэтгэх засаглалын үүрэг, үйл ажиллагааг тайлбарлаж чаддаг болно.
	10.13а. Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан үзэл баримтлалтай холбон тайлбарлах		
	10.13б. Засгийн газрын үйл ажиллагаа болон шийдвэрийг төрөл, хэлбэр, үүрэг, зориулалтаар нь ангилан, хувь хүний болон иргэдийн амьдралд үзүүлж буй нөлөөллийг судлан, дүгнэлт хийх		
10.13в. Иргэд засгийн үйлчилгээ авахад шаардлагатай мэдээллийг ашиглан, тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зааварчилга, зөвлөмж боловсруулах			

1.4 ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

БСШУС-ын сайдын 2018 оны А/425 тушаалаар батлагдсан “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д

- Суралцагчийн үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөнөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзлэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;
- Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж батлах ёстой гэж заасан байдаг.

СҮД-г томъёолсоны дараагаар үнэлгээний шалгуур, түүнд харгалзах гүйцэтгэлийн 4 түвшинг тодорхойлох ажил хийгдсэн.

Үнэлгээний шалгуур нь тодорхой зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт буюу түвшин юм.

Үнэлгээний шалгуур нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

1. Шалгуур (criterion)
2. Гүйцэтгэлийн түвшин (Achievement Standard, Performance Standard)

Шалгуур нь суралцагчийн хүрсэн үр дүн/амжилтыг нотлон харуулахад чиглэнэ. Өөрөөр хэлбэл, шалгуур нь суралцагчдын “Би юу хийх ёстой вэ?” гэдэг асуултад хариулна. Гүйцэтгэлийн түвшин нь

чанарын тодорхой түвшин (амжилт эсвэл гүйцэтгэл)-ийн тухай ойлголт юм. Энэ нь “Би яаж хийх ёстой вэ?” гэдэгт хариулна.

Үнэлгээний шалгуур нь СҮД-д хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлно. Үнэлгээний шалгуур нь СҮД-ээр хүрсэн амжилтаа харуулахын тулд сурагчид юу хийх ёстойг ойлгомжтой болгохоос гадна багш нарт сурагчдын амжилт/гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийх хүчин зүйлсийг тодорхойлоход нь тусална.

Тодорхой суралцахуйн зорилтын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт юм.

Үнэлгээний шалгуурт тавигдах шаардлага:

- Үнэлгээний шалгуур нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцтэй байх
- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг илрүүлэхүйц, хэмжихүйц байх;
- Үнэлгээний шалгуур нь давхцаагүй, нэг нэгнээсээ ялгаатай байх;
- Үнэлгээний шалгуур нь боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх;
- Үнэлгээний шалгуур нь ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байх, оролцогч бүх талууд /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичигдсэн байх;
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх гэсэн шаардлагуудыг харгалзан боловсруулсан.

Шалгуурт харгалзах гүйцэтгэлийн түвшинг боловсруулахдаа:

- Сурагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшингийн ялгаатай байдлыг агуулга эзэмшилт болон үйлийн хувьд тодорхой харуулах;
- Сурагчийн мэдлэг, чадвар, хандлага нь танин мэдэхүйн үйлийн хувьд түвшин ахих бүрд гүнзгийрч, тэлсэн байх;
- Сурагчийн мэдлэг, чадвар, хандлагыг оношилж, үнэлж, хөгжүүлэхэд зөв чиг баримжаа болохуйц байхыг тус тус тооцсон болно.

Суурь боловсролын 9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”, бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” бүлэг агуулгын шалгуур, түүнд харгалзах гүйцэтгэлийн түвшинг жишээ болгон үзүүлэв. Шалгуур, гүйцэтгэлийн түвшинг тодорхойлох нь ажлын дөрөвдэх үе шат байсан юм.

Жишээ-4.1

9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
1	Сурагч УИХ, Засгийн газар, шүүхийн эрх хэмжээг танилцуулсны үндсэн дээр үндэсний түвшинд шийдвэр яаж гардаг, түүнд иргэд хэрхэн оролцож болохыг тайлбарлаж чаддаг болно.	УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг.
		Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.
		Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцооны төрөл, хэлбэр, арга замуудыг тайлбарладаг.
		Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулдаг.
2	Сурагч эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр, иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж гэсэн хоёр үзүүлэлтээр ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлж чаддаг болно.	“Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж” гэсэн үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэм дэх үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлдог.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг.	<p>Ялгахдаа:</p> <ul style="list-style-type: none"> Ардчилсан улсад төрийн эрх мэдлийг зааглан хуваарилдаг болохыг хэлдэг. УИХ, Засгийн газар, шүүх гэж тус тусдаа байгууллага байдгийг л санадаг. 	<p>Ялгахдаа:</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсын үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хэрхэн зааглан хуваарилсаныг тайлбарладаг. УИХ, Засгийн газар, шүүх байгууллагын хэрэгжүүлдэг эрх мэдлийн ялгааг бүдүүвчээр дүрслэн үзүүлж өнгөц тайлбар хийдэг. 	<p>Ялгахдаа:</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсын үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилсан, эрх мэдлийг төвлөрүүлэхгүй байхын ач холбогдлыг тайлбарладаг. УИХ, Засгийн газар, шүүх байгууллагын эрх мэдлийн ялгааг бүдүүвчээр дүрслэн үзүүлж, тохирох тайлбарыг хэлдэг. 	<p>Ялгахдаа:</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсын үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилсан, эрх мэдлийг төвлөрүүлэхгүй байхын ач холбогдол, нэг болон хэсэг бүлэг хүний гарт эрх мэдэл төвлөрөхийн сөрөг талыг улс орнуудын жишээн дээр тайлбарладаг. УИХ, Засгийн газар, шүүх байгууллагын эрх мэдлийн ялгааг бүдүүвчээр дүрслэн үзүүлж, гол санааг нь дэлгэрүүлж оновчтой тайлбар хэлдэг.

Жишээ-4.2

10-р ангийн “Улс төр”

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
1	Сурагч өөрийн улсын жишээнд үндэслэн ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тодорхойлж, хэрэгжилтийг дүгнэж чаддаг болно.	Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тодорхойлдог.
		Судалгааны мэдээлэлд үндэслэн Монгол улсад ардчиллын үнэт зүйлсийн хэрэгжилт ямар байгаад үнэлгээ, дүгнэлт өгдөг.
2	Сурагч өөрийн улсын жишээнд үндэслэн төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, гүйцэтгэх засаглалын үүрэг, үйл ажиллагааг тайлбарлаж чаддаг болно.	Төрийн эрх мэдэл хуваарилалт, түүний зарчмыг тайлбарладаг.
		Гүйцэтгэх засаглал (Засгийн газар)-ын үүрэг, үйл ажиллагаа нь иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг тайлбарладаг.
		Төрийн үйлчилгээ (Засгийн газрын үйл ажиллагаа)-ний талаар өөрийн санал бодлоо илэрхийлдэг.

1.5 ЖИЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГ БОЛОВСРУУЛАХ

Анги тус бүрт бүх агуулгыг үзэж дууссаны дараагаар сурагч үнэлгээний зорилтын дагуу мэдлэг, ойлголт, чадвар, хандлагын хувьд ямар үр дүнд хүрэхийг бүх агуулга, үнэлгээний нэгжийн хүрээнд нэгтгэн боловсруулсан.

Суурь боловсролын 9-р анги, бүрэн дунд боловсролын 10-р ангийн жилийн суралцахуйн үр дүнг жишээ болгон үзүүлэв. Энэ нь шалгуур боловсруулах ажлын тавдахь үе шат байсан юм.

Жишээ-5.1

IX ангийн Нийгэм судлал хичээлээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн

Сургалтын хөтөлбөрийн зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг, ойлголт	Сурагч нийгмийн тодорхой айн хүрээнд өрнөж буй үзэгдэл, үйл явцыг танин мэдэж, хувь хүн ба нийгэм (нийгмийн харилцаа, харилцан үйлдэл), хувь хүн ба соёл (үндэсний соёл, соёлын өв, соёлын хэлбэр), хувь хүн ба эдийн засаг (хөдөлмөрийн зах зээл, мөнгө, банк), хувь хүн ба хууль (төрийн захиргаа, үйлчилгээ, хүний эрхийн ангилал), хувь хүн ба нийтийн удирдлага (үндэсний түвшний удирдлага, шийдвэр, эрх мэдлийн хуваарилалт, төр ба иргэний харилцаа)-ын тулгуур ойлголтуудыг тайлбарлаж, тодорхойлж чаддаг болно.
Чадвар	Сурагч аливаа нийгмийн үзэгдэл үйл явцад шалтгаан, холбоо хамаарлын үүднээс хандаж, жишээ баримттайгаар тодорхойлж, тайлбарлаж, үнэлж дүгнэж чаддаг болно.
Хандлага	Сурагч нийгмийн үзэгдэл үйл явцад оролцох хүсэл сонирхолтой, тохиолдол болон үйл явцад бодитой ханддаг, шүүмжлэх болон дэмжих байр сууриа илэрхийлж чаддаг болно.

Жишээ-5.2

X ангийн Нийгэм судлал хичээлээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн

Сургалтын хөтөлбөрийн зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг, ойлголт	Сурагч нийгмийг танин мэдэх арга, аргачлал ашиглан нийгэм, нийгмийн харилцаа (<i>нийгэмшилт, нийгмийн бүтэц, тогтвортой тал, нийгмийн судалгаа</i>), соёл (<i>соёлын бүтэц, ангилал</i>), эрх зүй (<i>хүний эрх ба үндсэн хууль, иргэний эрх зүйн харилцаа, иргэн ба төрийн харилцаа</i>), эдийн засаг (<i>макро эдийн засаг, санхүүгийн тогтолцоо</i>), улс төр (<i>ардчиллын суурь зарчим, үнэт зүйлс, төрийн эрх мэдэл хуваарилалт ба засгийн газрын үйл ажиллагаа</i>), олон улсын харилцаа (<i>Монгол улс ОУХ-ы оролцогч болох нь, Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоо, Монгол улсын улс төр, эдийн засгийн гадаад харилцааны хэлбэр</i>)-ы тулгуур ойлголтуудыг тодорхойлж, онолын гол үзэл баримтлалыг тайлбарлаж чаддаг болно.
Чадвар	Сурагч тоон болон чанарын судалгааны энгийн арга, аргачлал ашиглан нийгмийн амьдралтай холбоотой мэдээлэлд боловсруулалт хийж, үр дүнг нь тайлбарлаж чаддаг болно. Сурагч нийгмийн амьдралтай холбоотой асуулт, асуудал дэвшүүлж шийдвэрлэх явцдаа нийгмийн үзэгдэл, үйл явцад дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч чаддаг болно.
Хандлага	Сурагч нийгмийн үзэгдэл, үйл явцыг сонирхож судлах, түүнд оролцох хүсэл эрмэлзлээ илэрхийлж чаддаг болно. Сурагч нийгмийн бодит байдал, үйлдэл, тэдгээрийн мөн чанар, тулгамдсан асуудалд бодитой, олон өнцгөөс хандаж, өөрийн санал бодлоо илэрхийлж чаддаг болно.

1.6 НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү зөвлөмжийн хүрээнд суурь боловсролын 9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”, бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” бүлэг агуулгыг жишээ болгон үзүүлж байгаа билээ. Үнэлгээний шалгуурын дагуу сурагчийн мэдлэг, чадварыг үнэлэхийн тулд сургалтын хөтөлбөр болон сурах бичиг дэх тухайн агуулгад хамаарах сурагчийн зайлшгүй эзэмшсэн байх ёстой тулгуур ойлголт, нэр томьёоны тайлбар чухал байдаг.

9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”, бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” бүлэг агуулга дахь тулгуур ойлголт, тэдгээрийн тайлбарыг жишээ болгон үзүүлэв.

а. 9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага” бүлэг агуулгад хамаарах тулгуур үндсэн ойлголт, нэр томъёоны тайлбар:

- Үндэсний түвшний удирдлага, шийдвэр (төрийн удирдлага)- Парламент, засгийн газар, тэдгээрээс гаргадаг бодлого, шийдвэр
- Төр ба иргэний харилцаа - Иргэд төрийн байгууллагатай харилцах, шийдвэрт нь саналаа тусгах, өөрийн байр суурийг илэрхийлэх үйл явц
- Эрх мэдэл - Хүсэл зорилгодоо нийцүүлэн бусдын үйл байдлыг өөрчлөх чадвар
- Эрх мэдлийг хуваарилах - Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 салаа мөчирт хуваах
- Нийтийн эрх ашиг - Иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлсэн ойлголт
- Иргэдийн оролцоо - Иргэдээс төрийн байгууллага, ажилтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа оролдлогын цогц

б. 10-р ангийн “Улс төр” бүлэг агуулгын тайлбар:

- Суурь боловсролын сургалтын хөтөлбөрт улс төрийн агуулгыг 7 дугаар ангид сургуулийн түвшинд суралцагчдад хамааралтай шийдвэр гаргах үйл явцыг судалж, өөрөө оролцох хүсэл эрмэлзэлтэй болох, 8 дугаар ангид орон нутгийн төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг судлах замаар нийтийн удирдлагын тухай ойлголтоо хөгжүүлж, оролцох хүсэл эрмэлзэлтэй болох, 9-р ангид төрийн үйл ажиллагаанд иргэний оролцоо чухал болохыг асуудал дэвшүүлж, шийдвэрлэх замаар танин мэдэх, ойлголтоо хөгжүүлэхэд суралцсан.
- Бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” бүлгийн заавал судлах агуулгын хүрээнд “Ардчиллын суурь зарчим, иргэний улс төрийн итгэл үнэмшил, үнэт зүйл”, “Төрийн эрх мэдэл хуваарилалт ба засгийн газрын үйл ажиллагаа” гэсэн үндсэн хоёр агуулгыг судална.
- “Ардчиллын суурь зарчим, иргэний улс төрийн итгэл үнэмшил, үнэт зүйл” агуулгын хүрээнд Монгол улсын үндсэн хуулийн иргэний эрх, үүрэг, хариуцлагын тухай үзэл санаанд суурилан ардчилалын суурь зарчим, үнэт зүйлсийн талаар тодорхой үзүүлэлт, жишээ, баримтаар дэлгэрэнгүй судалж үндсэн ойлголтыг эзэмшиж, эргэцүүлэн дүгнэлт хийх замаар иргэний улс төрийн итгэл үнэмшил, үнэт зүйлийг өөртөө төлөвшүүлэхийг эрмэлзэх, энэ чиглэлээр тодорхой санал санаачилга гаргах чадваруудаа хөгжүүлнэ.
- “Төрийн эрх мэдэл хуваарилалт ба засгийн газрын үйл ажиллагаа” агуулгын хүрээнд Монгол улсын үндсэн хуулин дахь эрх мэдэл хуваарилах үзэл санаанд суурилан төрийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг судлан мэдэж, тэдгээрээс гаргаж буй шийдвэр, явуулж буй үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээг тодорхой жишээ баримтад суурилан дүн шинжилгээ хийж, түүнд нийцтэй хэлбэрээр оролцох үзэл хандлагатай болсон байна.

в. СҮД болон шалгуур боловсруулахад хэрэглэсэн үйл үгсийн тайлбар:

Үнэлгээний шалгуур боловсруулахад тавигддаг нэг үндсэн шаардлага нь суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх явдал юм. Жишээ нь: тооцоолох, хэлэлцэх, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, үнэлэх, шүүмжлэх гэх мэт. Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байх ёстой учраас үр дүнгийн тодорхойлолт тус бүрт сонгож авсан үгс нь ажиглагдаж, хэмжиж болох зан үйлийг бий болгох ёстой. СҮД болон шалгуур боловсруулахад хэрэглэсэн үйл үгсийн тайлбарыг хүргэж байна.

- Ялган таних: Нийгмийн тодорхой нэг үзэгдэл, үйл явцыг нөгөөгөөс нь ялгах, эсвэл ижил төстэй үзэгдлээс ялгах
- Тодорхойлох: Нийгмийн тодорхой үзэгдэл, үйл явц, түүний үндсэн зүй тогтол, хууль, суурь хөдлөшгүй шинж, мөн чанарыг бичгээр болон амаар тодорхойлох,
- Тайлбарлах: Үзэгдэл, үйл явдлын шалтгааныг, үйл явдал ба үзэл бодлын утга учир холбогдлыг, янз бүрийн үйлдэл, байр суурийн шалтгааныг тайлбарлах. Ойлголт, учир шалтгааны мэдлэгээ хэрэглэж, нотлох байдлаар нэмэлт мэдээллээр дэлгэрүүлэх

- Байр суурийг үнэлэх: Тодорхой нэг асуудлын хүчтэй болон сул талыг, дэмжиж буй байр суурийн зорилгыг, зорилгод хүрэхэд хэрэглэгдэж буй арга хэрэгслийг үнэлэх,
- Байр суурийг илэрхийлэх: Өөрийн байр суурьд хүрэхийн тулд ямар нэгэн хувилбараас сонгох эсвэл илүү өвөрмөц байр суурийг илэрхийлэх,
- Байр сууриа хамгаалах: Өөрийн байр суурийг хамгаалах, эсрэг талын байр суурийг харгалзан өөрийн үндэслэлийг гаргах, бусдын байр суурийг хүндэтгэх,
- Дүн шинжилгээ хийх (Анализ хийх): Нийгмийн үзэгдэл, үйл явцын утга учир, уялдаа холбоог олж тогтоох, зүй тогтол, адил болон ялгаатай талыг илрүүлэхийн тулд бүх талыг нарийвчлан харгалзаж үзэх
- Харьцуулах: Нийгмийн үзэгдэл, үйл явцын хоорондын адил төстэй, эсхүл ялгаатай байгааг багцаалах, хэмжих, тэмдэглэх
- Боловсруулах: Өгөгдсөн болон судалж буй мэдээлэлдээ үндэслэж, зохих санал, дүгнэлтийг системтэйгээр боловсруулах
- Тунгаан бодох: Нотолгоо, шийдвэрийг яагаад гаргах болсон учир шалтгааныг харуулах, учир шалтгааны нотлох баримтыг оновчтой харуулах
- Сайжруулах: Чанарыг сайжруулах, эсхүл илүү тодорхой болгох үүднээс өөрчлөлт хийх, хувиргах, зохилдуулах
- Зохион байгуулах: Харилцан уялдаатай хэсгүүдийг, харилцан урган гарах дарааллыг нэг бүхэлд оруулан зохион байгуулах
- Илтгэх: Тодорхой сэдвээр мэдээлэх, тодорхой сэдвийг хөндөх, ялангуяа дүрс, зураг, цахим дата, үзүүлэн гэх мэтээр баяжуулж үзүүлэх

Хоёр. Суурь, бүрэн дунд боловсролын нийгэм судлал хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

Энэхүү зөвлөмжийн хүрээнд жишээ болгон суурь боловсролын 9-р ангийн “Хувь хүн ба нийтийн удирдлага”, бүрэн дунд боловсролын 10-р ангийн “Улс төр” бүлэг агуулгын хүрээнд үнэлгээний шалгуурын дагуу үнэлгээг хэрхэн хийж болохыг үзүүлэв. Бүтээлчээр, баяжуулан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Анги: IX

Сонгож авсан бүлэг агуулга: “Хувь хүн ба нийтийн удирдлага”

Үнэлгээний нэгж: “Хувь хүн ба нийтийн удирдлага”

Суралцахуйн зорилт (Хөтөлбөрийн агуулга):

- 9.5а. УИХ, Засгийн газар, шүүхийн байгууллагын эрх хэмжээ, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлог, уялдаа холбоог судлах, эрх мэдэл хуваарилалт гэж юу болохыг тодорхойлох
- 9.5б. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг судлах, оролцох шаардлагын үндэслэл дэвшүүлэх
- 9.5в. Улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг харьцуулан судалж, ардчилалд иргэдийн оролцоо ямар ач холбогдолтойг тайлбарлах

Анги: X

Сонгож авсан бүлэг агуулга: “Улс төр

Үнэлгээний нэгж: “Улс төр”

Суралцахуйн зорилт (Хөтөлбөрийн агуулга):

- 10.12а. Ардчиллын тулгуур үнэт зүйлсийг Монгол улсын Үндсэн хуулин дахь иргэний эрх, үүрэг, хариуцлагын тухай үзэл баримтлалтай холбон тодорхойлох
- 10.12б. Монгол улсад ардчиллын тулгуур үнэт зүйлс хэрхэн хэрэгжиж байгааг судалгааны эх сурвалж, баримт жишээнд үндэслэн дүгнэлт хийх
- 10.12в. Эх сурвалжийг судлан, ардчиллын үнэт зүйлсийн хэрэгжилтийн талаар дүгнэх
- 10.13а. Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан үзэл баримтлалтай холбон тайлбарлах

- 10.13б. Засгийн газрын үйл ажиллагаа болон шийдвэрийг төрөл, хэлбэр, үүрэг, зориулалтаар нь ангилан, хувь хүний болон иргэдийн амьдралд үзүүлж буй нөлөөллийг судлан, дүгнэлт хийх
- 10.13в. Иргэд засгийн үйлчилгээ авахад шаардлагатай мэдээллийг ашиглан, тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зааварчилга, зөвлөмж боловсруулах

2.1 ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Үнэлгээ хийхдээ төлөвлөхгүй байх нь багш нарт тодорхой бэрхшээлийг бий болгодог. Үүнийг шийдвэрлэх арга зам нь үнэлгээгээ сургалтын хөтөлбөр, үнэлгээний зорилт, шалгууртайгаа уялдуулан оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх явдал юм. Үнэлгээний олон арга хэрэгсэлтэй байж оновчтой сонголт хийн, хэрэглэж сурах шаардлагатай.

2.1.1.А НЭГЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ: 9-Р АНГИ

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Үнэлгээний зорилт			Үр дүнгийн шалгуур
		1	2	3	
5. Хувь хүн ба нийтийн удирдлага	5.1 Сурагч УИХ, Засгийн газар, шүүхийн эрх хэмжээг танилцуулсаны үндсэн дээр үндэсний түвшинд шийдвэр яаж гардаг, түүнд иргэд хэрхэн оролцож болохыг тайлбарлаж чаддаг болно.	+	+		5.1.1 УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг.
		+	+		5.1.2 Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.
		+	+		5.1.3 Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцооны төрөл, хэлбэр, арга замуудыг тайлбарладаг.
			+	+	5.1.4 Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулдаг.
	5.2 Сурагч эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр, иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж гэсэн хоёр үзүүлэлтээр ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлж чаддаг болно.			+	+

¹ Мэдлэг ойлголт

² Чадвар

³ Хандлага

2.1.1.Б НЭГЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ: 10-Р АНГИ

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Үнэлгээний зорилт			Үр дүнгийн шалгуур
		1	2	3	
5. Улс төр	5.1 Сурагч өөрийн улсын жишээнд үндэслэн ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тайлбарлаж, хэрэгжилтийг дүгнэж чаддаг болно.	+	+		Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тодорхойлдог.
			+	+	Судалгааны мэдээлэлд үндэслэн Монгол улсад ардчиллын үнэт зүйлсийн хэрэгжилт ямар байгаад үнэлгээ, дүгнэлт өгдөг.
	5.2 Сурагч өөрийн улсын жишээнд үндэслэн төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, гүйцэтгэх засаглалын үүрэг, үйл ажиллагааг тайлбарлаж чаддаг болно.	+	+		Төрийн эрх мэдэл хуваарилалт, түүний зарчмыг тайлбарладаг.
		+	+		Гүйцэтгэх засаглал (Засгийн газар)-ын үүрэг, үйл ажиллагаа нь иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг тайлбарладаг.
		+	+	Төрийн үйлчилгээ (Засгийн газрын үйл ажиллагаа)-ний талаар өөрийн санал бодлоо илэрхийлдэг.	

2.1.2.А ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ: 9-Р АНГИ

Явцын болон үр дүнгийн үнэлгээг хийх сорил даалгавар, дасгал ажлын хуудас зэргийг боловсруулахдаа нэгжийн үнэлгээний зорилт, шалгуурт үндэслэн юуг үнэлэхээ нарийвчлан шалгуур үзүүлэлтээр тодорхой болгох нь үнэлгээний төлөвлөлтийн чухал хэсэг юм.

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур үзүүлэлт
Мэдлэг ойлголт	Тодорхойлж, тайлбарлах мэдлэг, ойлголт: <ul style="list-style-type: none"> • Үндэсний түвшний удирдлага, шийдвэр (төрийн удирдлага)- Парламент, засгийн газар, тэдгээрээс гаргадаг бодлого, шийдвэр хэрхэн гардаг • Төр ба иргэний харилцаа – Парламент, засгийн газраас гаргадаг бодлого, шийдвэр дэх иргэний оролцоо, нийтийн эрх ашиг, • Эрх мэдлийг хуваарилалт <ul style="list-style-type: none"> - Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 салаа мөчирт хуваах, - УИХ, Засгийн газар, Шүүхийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаа - Ардчилсан болон ардчилсан бус дэглэм бүхий нийгмүүд дэх иргэний үнэт зүйлс
Чадвар	Харьцуулалт хийх, ялгах, дүгнэх, тайлбарлах: <ul style="list-style-type: none"> • УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгах • Ардчилсан болон ардчилсан бус дэглэм бүхий нийгмүүд дэх иргэний үнэт зүйлсийн ялгааг гаргах • Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцооны төрөл, хэлбэр, арга замын ялгааг гарган тайлбарлах Холбогдох мэдээлэл, сурвалжийг боловсруулж, үр дүнг нь бүдүүвч, хүснэгт, зураглал зэргийн тохирохыг сонгон нэгтгэж харуулсан байдал: <ul style="list-style-type: none"> • УИХ, Засгийн газар, Шүүх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан засаглал хуваарилалтын талаар ойлголттой болсоноо бүдүүвч, схемээр илэрхийлэх • Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн онцлог, үйл ажиллагааны ялгаатай талыг вен диаграммаар гаргаж, тайлбарлан бичих • Төр ба иргэний харилцааг бүдүүвчээр илэрхийлэх • Иргэдийн оролцооны төрөл, хэлбэр, арга замыг хүснэгтэд ангилах

	Хандлага	<p>Хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ямар асуудлыг судлах сонирхолтой байгаагаа илэрхийлж, оролцох хүсэл эрмэлзлээ илэрхийлж буй байдал:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжийг судалж, оролцох хүсэл эрмэлзлээ илэрхийлэх • Шүүх үйл ажиллагааны зарчим, шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулах • Ардчиллыг бэхжүүлэхэд иргэдийн оролцоо, хувь нэмэр чухал болох тухай эргэцүүлэх үндсэн дээр ардчиллын үнэт зүйлс, итгэл үнэмшлийг өөртөө төлөвшүүлэхийг эрхэмлэх
--	----------	---

2.1.2.Б ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ: 10-Р АНГИ

Үнэлгээний зорилт		Үнэлгээний шалгуур үзүүлэлт
Мэдлэг ойлголт		<ul style="list-style-type: none"> • Ардчиллын тулгуур үнэт зүйлсийг Монгол улсын үндсэн хуулин дахь иргэний эрх үүрэг, хариуцлагын тухай үзэл баримтлалтай холбон тодорхойлох • Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулинд тусгагдсан үзэл баримтлалтай холбон судлан ойлгох
Чадвар		<ul style="list-style-type: none"> • Монгол улсад ардчиллын тулгуур үнэт зүйлс хэрхэн хэрэгжиж байгааг судалгааны эх сурвалж, баримт жишээнд үндэслэн дүгнэлт хийх • Засгийн газрын үйл ажиллагаа болон шийдвэрийг төрөл, хэлбэр, үүрэг зориулалтаар нь ангилан, хувь хүний болон иргэдийн амьдралд үзүүлж буй нөлөөллийг судлан, дүгнэлт хийх
Хандлага		<ul style="list-style-type: none"> • Ардчиллын үнэт зүйлсийг хэрэгжүүлэх эрмэлзлээ илэрхийлэх • Иргэд засгийн үйлчилгээ авахад шаардлагатай мэдээллийг ашиглан, тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зааварчилгаа, зөвлөмж зэргийг бичиж сурах

2.2 ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛБЭР:

Явцын болон үр дүнгийн үнэлгээг хэзээ хийх, ямар арга, хэрэгсэл ашиглан хийх, энэ нь хэдэн хувийг эзлэхийг тодорхойлох нь үнэлгээний төлөвлөлт хийх гол хэсэг юм.

№	Үнэлгээний хэлбэр	Явцын үнэлгээ	Үр дүнгийн үнэлгээ
1	Үнэлгээний зорилго	Хичээл, сургалтын явцад суралцагчдын агуулга эзэмшилтийн талаар мэдээлэл цуглуулах, энэ мэдээллийг өдөр тутмын сургалтын үйл ажиллагаандаа ашиглана.	Бүлгийн төгсгөлд суралцагчийн олж авсан мэдлэг, чадварын түвшинг тогтооно.
2	Үнэлгээний давтамж	Хичээл, сургалтын турш, тухай бүрт нь үнэлгээ хийгдэнэ.	Бүлгийг судалсаны эцэст үнэлгээ хийгдэнэ.

3	Үнэлгээний арга хэрэгсэл, нотлох баримт	<p>Хичээл, сургалтын явцад дараах арга, хэрэгслийг ашиглан үнэлгээ хийгдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Бичгийн арга - Бүдүүвч схем, хүснэгт, вен диаграммаар илэрхийлэх • Бичгийн арга - Ажлын хуудас, түүний гүйцэтгэлээр • Аман арга - Танилцуулга бэлтгэж тайлбарлан ярих, асуултад хариулах • Аман арга - Хэлэлцүүлэгт оролцох, танилцуулга хийх, тайлбарлах, илтгэх, мэтгэлцэх • Дүрд тоглох - Мини шүүх • Ажиглалтын арга - Багшийн тэмдэглэл, сурагчийн дэвтэр 	Бүлгийн төгсгөлд тест, сорил даалгавраар үнэлнэ.
4	Анхаарах зүйл, санамж	<p>Багш хичээл тус бүрээр хүрэх үр дүн болон түүнд хүрсэн эсэхийг тодорхойлох амжилтын шалгуурыг боловсруулан сурагчид хүрсэн эсэх талаар дээр дурдагдсан арга, хэрэгслийг ашиглан үнэлгээний нотлох баримт, мэдээлэл цуглуулж сурагчдыг үнэлж, хөгжлийг нь дэмжин ажиллана. Үнэлгээний хэдэн хувь эзлэхийг багш тооцоолно. Багш сурагчдын хийж гүйцэтгэх ажлын хуудас, дасгал, даалгаврыг бэлтгэж, үнэлэх үнэлгээний хуудсыг (рубрик) бэлтгэж ашиглана. Мөн шалгуур тус бүрийн хүрэх гүйцэтгэлийн 4 түвшинг ашиглана.</p>	<p>Бүлгийн төгсгөлд хийгдэж буй сорил даалгаврын гүйцэтгэлээр үнэлнэ. Үүний тулд даалгавар сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээг хэмжээсжүүлж, оноожуулж, тэдний мэдлэг, чадварын түвшинг тодорхойлно.</p> <p>Даалгаврын гүйцэтгэлээр I, II, III, IV түвшний аль шалгуурыг хангаж буйгаас нь хамааруулж зохих дүн үнэлгээг өгнө.</p>

2.2.1 ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ (ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХДЭЭ НОТЛОГООНД СУУРИЛСАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ):

Сургалтын явцад явцын үнэлгээ хийнэ. Явцын үнэлгээ нь суралцахуйг эргэх мэдээллээр хангах, сурлагын ахиц, амжилтыг суралцахуйн болон багшлахуйн үйл ажиллагаатай холбон тодорхойлоход тусалдаг. Ингэснээр багш сургалтын үйл явцад арга зүйгээ оновчтой сонгох, сурагчдынхаа нас, сэтгэхүйд тохируулах, улмаар арга зүйгээ сайжруулах зэрэг олон талын боломж олгоно.

2.2.1.1 “Хувь хүн ба нийтийн удирдлага” үнэлгээний нэгжийн зарим шалгуур тус бүрээр суралцахуйн үр дүнд хүрсэнийг харуулах баримт, нотолгоо цуглуулах, түүнийг шинжлэх

Жишээ-1. Шалгуур: УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг.


Үнэлгээний хэлбэр: Явцын үнэлгээ (Хичээлийн явцад болон бие дааж гүйцэтгэх дасгал, даалгавар өгч үнэлнэ.)

Үнэлгээний даалгавар:


Даалгавар 1. Өгөгдсөн мэдээллийг ашиглан УИХ, Засгийн газар, Шүүх байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагаатай холбон хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын онцлог ба харилцан хамаарлыг бүдүүвчээр илэрхийлээрэй.

Монгол улсын үндсэн хуулиас:


УИХ	ЗАСГИЙН ГАЗАР	ШҮҮХ
“Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”	“Монгол улсын засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”	“Монгол улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”
УИХ-ын бүрэн эрхийг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд: - Хууль батлах - Төрийн гадаад, дотоод бодлогын үндсийг тодорхойлох - Засгийн газрын бүрэлдэхүүнийг тогтоох, гишүүдийг томилох, өөрчлөх, огцруулах - Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, улсын төсөв батлах - Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо, эрх зүйн үндсийг тогтоох - Монгол улсын олон улсын гэрээг соёрхон батлах	Засгийн газрын бүрэн эрхийг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд: - Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг хангах - Нийгмийн хөгжил, төсөв, санхүүг төлөвлөх, хэрэгжүүлэх - Хүрээлэн буй орчныг хамгаалах, баялгийг зүй зохистой ашиглах - Орон нутгийн захиргааг удирдан чиглүүлэх - Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах - Төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх - Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах - Бусад улс оронтой гэрээ хэлэлцээр хийх, хэрэгжүүлэх	Шүүхийн бүрэн эрхийг дараах байдлаар тусгасан байдаг Үүнд: Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: - Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх - Давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх; - Хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар асуудлыг хянан шийдвэрлэх; - Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах



УИХ-ын онцлог тал
 УИХ болон ЗГ-ын нийтлэг тал
 ЗГ-ын онцлог тал



УИХ-ын онцлогийг хадгалсан жишээ
 УИХ болон Шүүхийн онцлогийг хадгалсан жишээ
 ЗГ-ын онцлогийг хадгалсан жишээ



УИХ-ын онцлог тал
 УИХ болон Шүүхийн нийтлэг тал
 Шүүхийн онцлог тал

Даалгавар 2. Дасгалыг гүйцэтгээрэй.

Үнэлэх арга, хэрэгсэл: Бичгийн болон аман аргыг хослуулж үнэлнэ. Сурагчийн дэвтэр дэх гүйцэтгэсэн тэмдэглэл, тайлбарлан ярьж буй байдалд тулгуурлан багшийн зүгээс доорх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээний рубрик ашиглан үнэлгээ өгнө.

Шалгуур үзүүлэлт-1. УИХ, Засгийн газар, Шүүх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан эрх мэдэл хуваарилалтын талаар ойлголттой болсоноо бүдүүвч, схемээр илэрхийлсэн байдал (*багшийн тэмдэглэл, сурагчдын дэвтэр*)

Шалгуур үзүүлэлт-2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн онцлог, үйл ажиллагааны ялгаатай талыг Вен диаграмаар гаргаж, тайлбарлан бичсэн байдал (*багшийн тэмдэглэл, сурагчдын дэвтэр, тайлбар яриа*)

Сурагчийн хийсэн даалгаврын гүйцэтгэлийг ажиглаж үнэлэх рубрик:

№	Шалгуур үзүүлэлт	Маш сайн	Сайн	Боломжийн боловч дэмжлэг хэрэгтэй	Цаашид ажиллах шаардлагатай.
		А	В	С	Д
1	Даалгавар 1. Бүдүүвч, схемээр илэрхийлсэн байдал	Засаглал хуваарилалтын дагуу холбогдох төрийн 3 байгууллагуудыг харгалзуулан бүрэн зөв схемд оруулсан. Холбогдох нөхцөл, үндэслэгээг дахин бүтэцлэх болон дүн шинжилгээ хийж оновчтой тайлбарласан.	Засаглал хуваарилалтын дагуу холбогдох төрийн 3 байгууллагуудыг харгалзуулан схемд оруулсан. Холбогдох нөхцөл, үндэслэгээг гарган тайлбарлаж бичсэн.	Засаглал хуваарилалтын дагуу холбогдох төрийн 3 байгууллагуудыг схемд оруулахдаа зарим нь оновчтой бус. Холбогдох нөхцөл, үндэслэгээг заримыг нь дутуу тайлбарласан.	Засаглал хуваарилалтын дагуу холбогдох төрийн 3 байгууллагуудыг схемд оруулахдаа бүхэлд нь хольж будилсан эсвэл илэрхийлээгүй. Холбогдох нөхцөл, үндэслэлийн тайлбар нь оновчтой бус эсвэл тайлбарлаагүй.
2	Даалгавар 2. Үрдүг вен диаграмаар илэрхийлэх	Диаграмд ижил болон ялгаатай талыг харилцан хамааралд нь бүрэн гаргаж илэрхийлсэн. Холбогдох нөхцөл, үндэслэгээг дахин бүтэцлэх болон дүн шинжилгээ хийж оновчтой тайлбарласан.	Диаграмд ижил болон ялгаатай талыг гаргаж илэрхийлсэн. Холбогдох нөхцөл, үндэслэгээг гарган тайлбарлаж бичсэн.	Диаграмд ижил болон ялгаатай талыг илэрхийлэхдээ зарим зүйл нь оновчтой бус. Холбогдох нөхцөл, үндэслэгээг заримыг нь дутуу тайлбарласан.	Диаграмд ижил болон ялгаатай талыг илэрхийлэхдээ бүхэлд нь хольж будилсан, эсвэл илэрхийлж чадаагүй. Холбогдох нөхцөл, үндэслэлийн тайлбар нь оновчтой бус эсвэл тайлбарлаагүй.

Багш рубрикийн дагуу ажигласнаа тэмдэглэх үнэлгээний хүснэгт: Загвар жишээ

№	Ажиглах сурагчдын нэрс	Шалгуур үзүүлэлт								Үнэлгээ		
		1				2				1	2	Түвшин
		a	b	c	d	a	b	c	d			
1	А сурагч									a	b	VII-VIII
2	Б сурагч									b	b	V-VI
3	В сурагч									b	c	III-IV
4	Г сурагч									d	d	I-II

Сурагчдын гүйцэтгэлээр нь үнэлсэн тэмдэглэлдээ тулгуурлан “УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг” гэсэн шалгуурыг аль түвшинд хангаж байгааг доорх хүснэгтэд буй мэдээлэлд тулгуурлан дээрх байдлаар тодорхойлох боломжтой юм.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг.	Ялгахдаа: -Ардчилсан улсад төрийн эрх мэдлийг зааглан хуваарилдаг болохыг хэлдэг. -УИХ, Засгийн газар, шүүх гэж тус тусдаа байгууллага байдгийг л санадаг.	Ялгахдаа: -Монгол улсын үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хэрхэн зааглан хуваарилсаныг тайлбарладаг. -УИХ, Засгийн газар, шүүх байгууллагын хэрэгжүүлдэг эрх мэдлийн ялгааг бүдүүвчээр дүрслэн үзүүлж өнгөц тайлбар хийдэг.	Ялгахдаа: -Монгол улсын үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилсан, эрх мэдлийг төвлөрүүлэхгүй байхын ач холбогдлыг тайлбарладаг. -УИХ, Засгийн газар, шүүх байгууллагын эрх мэдлийн ялгааг бүдүүвчээр дүрслэн үзүүлж, тохирох тайлбарыг хэлдэг.	Ялгахдаа: -Монгол улсын үндсэн хуулинд төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилсан, эрх мэдлийг төвлөрүүлэхгүй байхын ач холбогдол, нэг болон хэсэг бүлэг хүний гарт эрх мэдэл төвлөрөхийн сөрөг талыг улс орнуудын жишээ татан тайлбарладаг. -УИХ, Засгийн газар, шүүх байгууллагын эрх мэдлийн ялгааг бүдүүвчээр дүрслэн үзүүлж, гол санааг нь дэлгэрүүлж оновчтой тайлбар хэлдэг.

Жишээ-2. Шалгуур: “Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох оролцох боломж” гэсэн үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэм дэх үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлдог.

Үнэлгээний хэлбэр: Явцын үнэлгээ (Хичээлийн явцад болон бие дааж гүйцэтгэх ажлын хуудас өгч түүний гүйцэтгэлээр нь үнэлнэ.)

Үнэлгээний даалгавар:

Даалгавар 1. Сурах бичгийн 81-р хуудсанд байгаа жишээг уншиж дараах асуултад ажлын хуудасны дагуу хариулаарай.

Ажлын хуудас 1: Жишээг уншаад өөрийн сонирхсон асуултаа бичнэ үү? (1-3 асуулт)

№	Асуулт
1	
2	
3	

Ажлын хуудас 2: “Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр” болон “төрийн хэрэгт иргэд оролцох боломж” гэсэн хоёр үзүүлэлтээр өгөгдсөн жишээ ардчилсан ба ардчилсан бус дэглэмийн алинд хамаарахыг ялган тодорхойлоорой.

	Ардчилсан	Ардчилсан бус
Ард түмэн хууль тогтоох парламентийг сонгожээ. Хууль тогтоогчид хуулийн төсөл боловсруулж иргэдээс санал авч хууль баталдаг.		
Нэгэн улсад хувьсгал гарч, армийн генерал Ерөнхийлөгч болжээ. Ерөнхийлөгч хууль гаргаж, шүүгчдийг болон бусад төрийн албаны хүмүүсийг томиллоо. Таван жил тутамд Ерөнхийлөгчийн сонгууль болно. Гэвч хэн ч Ерөнхийлөгчтэй өрсөлдөхгүй.		

Хаан буюу хатан хаан улсын хууль батлаж хэрэгжүүлэхгүй. Тэд албан ёслолын үүрэг гүйцэтгэнэ. Ард түмнээс сонгогдсон парламент хууль баталж, ерөнхий сайд, засгийн газрыг сонгоно. Сонгууль тогтмол хугацаанд болдог.		
Улсын тэргүүн ард түмнээс сонгогдохгүй, харин эцгээсээ хэргэм зэргийг нь өвлөн авдаг бөгөөд өөрөө хууль гаргаж хэрэгжүүлнэ. Тэр хуулийг ард түмнээр дагаж мөрдүүлэхийн тулд өөрийн цагдаатай байна. Тэр зөвлөлийн санал зөвлөмжийг сонсох боловч түүнийг нь заавал баримтлах албагүй.		
Хэсэг тэргүүлэх хүмүүс хууль гаргана. Тэд мөн цэрэг цагдааг хяналтандаа байлгана. Хэвлэлийнхэнд юуг хэвлэх, юуг болохгүйг заана. Тэр улсад сонгууль болдоггүй. Тэргүүлэх хүмүүсийн ганц нам л байна.		
Хууль тогтоогчид хотын бүх иргэдийн сар бүрийн нээлттэй цуглаан дээр иргэдийн санал болгосон хуулийн төсөл боловсруулна. Дараа нь тэр төслийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар иргэдийн санал хураана.		

Үнэлэх арга хэрэгсэл: Ажлын хуудас түүний гүйцэтгэлээр үнэлнэ. Ажлын хуудас гэдэг нь төлөвлөгдсөн болон хийгдэж буй ажлыг тэмдэглэх хуудас юм. Мөн суралцагчийн гүйцэтгэх дасгалыг багтаасан хуудас.

Ажлын хуудасны гүйцэтгэлийг үнэлэх аргачлал:

Шалгуур үзүүлэлт 1 Өгөгдсөн жишээг уншаад бусдаас оновчтой асуулт асууж чадаж буй эсэх

Шалгуур үзүүлэлт 2. Ардчилсан болон ардчилсан бус дэглэм бүхий нийгмүүд дэх иргэний үнэт зүйлсийн ялгааг гаргасан байдал

Ажлын хуудас 1: Жишээг уншаад өөрийн сонирхсон асуултаа бичнэ үү? (1-3 асуулт)

Блумын шатлалаар боловсруулсан асуултыг үнэлнэ.

Шалгуур	Сэргээн санах	Ойлгох	Хэрэглэх	Дүн шинжилгээ хийх	Нэгтгэн дүгнэх	Үнэлэх
Өгөгдсөн жишээг уншаад бусдаас оновчтой асуулт асууж чадаж буй эсэх						

Мөн нээлттэй асуулт асууж байна уу? хаалттай асуулт асууж байна уу? гэдгээр нь ч үнэлж болно.

Нээлттэй	Хаалттай

Нийгмийн ухааны шинжлэн судлах болон асуудал шийдвэрлэх арга барилыг эзэмших үйл явц нь асуулт асуух /сонирхол/ - аас эхэлдэг. Ажлын хуудас-1 т бичсэн 3 асуултыг дээрх хоёр үнэлгээний хуудасны аль нэгээр нь үнэлж, сурагчдад зохих зөвлөгөөг өгөхөд анхаарна. Өөрөөр хэлбэл, дан хаалттай эсвэл нэрлэх түвшний асуултууд асуугаад байгаа сурагчийн энэ чадварыг нь сайжруулахад анхаарч ажиллана гэсэн үг.

Ажлын хуудас 2: “Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр” болон “төрийн хэрэгт иргэд оролцох боломж” гэсэн хоёр үзүүлэлтээр өгөгдсөн жишээ ардчилсан ба ардчилсан бус дэглэмийн алинд хамаарахыг ялган тодорхойлоорой гэсэн даалгаврын ажлын хуудасны гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Маш сайн	Сайн	Боломжийн боловч дэмжлэг хэрэгтэй	Цаашид ажиллах шаардлагатай.
		А	В	С	Д
1	Ялган тодорхойлсон байдал	Өгөгдсөн жишээг бүгдийг нь буюу дийлэнх олонхийг нь зөв ялган бичсэн	Өгөгдсөн жишээний тал хувийг нь зөв ялган тодорхойлсон	Өгөгдсөн жишээний талаас доош хувийг ялган тодорхойлсон	Өгөгдсөн жишээг бүгдийг нь буруу ялган тодорхойлсон.
2	Өгөгдсөн хоёр үзүүлэлтээр ялган бичсэн үндэслэлээ оновчтой тайлбарласан байдал	-Жишээг ялган тодорхойлж, тайлбарлаж чадсан. -Тодорхойлолтыг гаргахаа хичээлийн агуулгатай холбон асуултад өгөгдсөн хоёр үзүүлэлтийг хэрэглэсэн. -Ойлголтын уялдаа холбоонд гол санааг нь оновчтой гаргаж чадсан, дүгнэлт тодорхой. -Жишээг ойлгож мэдлэгээ өөрийн санааг нотолход оновчтой, үнэмшилтэй, өөртөө итгэлтэйгээр холбогдох нөхцөл, үндэслэгээг бүрэн гаргасан	-Жишээний талыг нь зөв ялган тодорхойлж, тайлбарлаж чадсан. -Өгөгдсөн жишээг ойлгож, холбогдох нөхцөл, үндэслэгээг өгөгдсөн хоёр асуултад суурилан үндэслэлийг тодруулсан боловч бүрэн биш, итгэл үнэмшилтэй бус .	-Тодорхойлолтыг гаргахаа хичээлийн агуулгатай холбон асуултад өгөгдсөн хоёр үзүүлэлтийг хэрэглэсэн боловч бүрэн дүүрэн зөв тайлбарлаж чадаагүй. -Ойлголтын уялдаа холбоо, гол санааг сайн гаргаж чадаагүй -Өгөгдсөн жишээний ойлголгүйгээр зөвхөн өөрийн бодлыг илэрхийлсэн. -Холбогдох нөхцөл, үндэслэлийг дэвшүүлээгүй	-Жишээний ялган тодорхойлж чадаагүй.

Багш рубрикийн дагуу ажлын хуудасны гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний хүснэгт: Загвар жишээ

№	Ажиглах сурагчдын нэрс	Ажиглах үзүүлэлт								Үнэлгээ		
		1				2				1	2	Түвшин
		a	b	c	d	a	b	c	d			
1	А сурагч									a	b	VII-VIII
2	Б сурагч									b	b	V-VI
3	В сурагч									b	c	III-IV
4	Г сурагч									d	d	I-II

Сурагчдын ажлын хуудасны гүйцэтгэлээр нь үнэлсэн тэмдэглэлдээ тулгуурлан “Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох оролцох боломж” гэсэн үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэмүүд дэх үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлдог.” гэсэн шалгуурыг аль түвшинд хангаж байгааг доорх гүйцэтгэлийн түвшинд тулгуурлан тодорхойлох боломжтой юм.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
“Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох оролцох боломж” гэсэн үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэмүүд дэх үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлдог.	Тодорхойлохдоо: -Ардчилсан ба ардчилсан бус дарангуйлагч улс орнууд байдгийг хэлдэг. Зарим нэг улсыг жишээ болгон нэрлэдэг.	Тодорхойлохдоо: -“Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж” гэсэн 2 үзүүлэлтийн аль нэгийг хүрээнд нь ардчилсан ба ардчилсан бус дэглэмийн шинж чанарыг тодорхойлж хэлдэг.	Тодорхойлохдоо: -“Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж” гэсэн 2 үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус дэглэмийн шинж чанарыг оновчтой тодорхойлж хэлдэг. -Өгөгдсөн кейс, жишээнээс аль нь ардчилсан ба ардчилсан бус дэглэмд хамаарахыг ялгадаг.	Тодорхойлохдоо: -“Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох боломж” гэсэн 2 үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус дэглэмийн шинж чанарыг оновчтой тодорхойлж, жишээгээр дэлгэрүүлдэг. -Өгөгдсөн кейс, жишээнээс аль нь ардчилсан ба ардчилсан бус дэглэмд хамаарахыг ялгаж, тэдгээр нийгмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг тодорхойлж хэлдэг. -Ардчилсан нийгэм дэх иргэний эрхэмлэх зүйлсийг нэрлэж, өөртөө төлөвшүүлэхийг эрмэлздэг.

Жишээ-3 Шалгуур: Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулдаг.

Үнэлгээний хэлбэр: Явцын үнэлгээ (Хичээлийн явцад хийсэн гүйцэтгэлээр нь үнэлнэ.)

Үнэлгээний даалгавар:

Даалгавар 1. Сурагчид багт хуваагдан сурах бичгийн 88-р хуудсанд байгаа шүүх үйл ажиллагааны загварыг дуурайн дүрийн тоглолт хийж үзүүлнэ.

Үнэлэх арга, хэрэгсэл: Аман аргаар үнэлнэ. Шүүх үйл ажиллагааны загварыг дуурайн дүрийн тоглолтыг хийж үзүүлэхдээ шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг, шүүх хуралдаан, түүний дараалал, шүүх үйл ажиллагааны зарчмуудын талаар тайлбарыг хэлж, жишээгээр дэлгэрүүлж, илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлж, мэтгэлцэж буй эсэхийг нь үнэлгээний хуудас ашиглан үнэлнэ.

Дүрийн тоглолт хийх сургалтын аргын онцлогт тохирсон үнэлгээг хэрэглэх бөгөөд үнэлгээний арга, хэлбэр, шалгуур нь суралцагчдад нээлттэй, тэдгээрийн саналыг тусгасан байх нь ихээхэн чухал. Учир нь суралцагчийн эрхийг хүндэтгэж буй хэрэг бөгөөд үнэлгээний талаарх эерэг зөв ойлголт, хандлага төлөвшихэд ач холбогдолтой. Үнэлгээ суралцагчдад хаалттай, тэдний саналыг харгалзахгүй байх нь суралцагчдын нийгэмшилд сөрөг нөлөөтэй.

Шалгуур үзүүлэлт: Шүүх хуралдааны загварыг дуурайн хэлэлцэх замаар шүүхийн үйл ажиллагааны зарчим, мөн чанарыг танин мэдэж чадсан эсэх

Шүүх хуралдааны явц дахь хэлэлцүүлгийг үнэлэх нь (Загвар):

Д/д	Үнэлгээний шалгуур	Үнэлгээ			
		1	2	3	4
1	Мэтгэлцэх, харилцан буулт, зөвшилцлийн хууль ёсны байдлыг харгалзан үзэж буй байдал				
2	Санал зөрөлдөөнтэй гол зангилаа асуудлыг ил тод илэрхийлж буй байдал				
3	Хэлэлцүүлгийн үед хувь хүн дээр анхаарахаас илүү үзэл бодол байр суурийг хэлэлцэж шийдвэрлэж чадаж буй байдал				
4	Санал нэгдэх, эсвэл санал зөрж байгаа үед үндэслэлээ хэрхэн гаргаж чадаж байгаа байдал				
5	Харилцан биесээ хүндэтгэн харьцаж буй байдал				
6	Хэлэлцүүлгийн дүрмийг мөрдж буй байдал				

Зааварчилгаа: 1- байхгүй, 2 – бага зэрэг, 3 – ихэнх тохиолдолд, 4 - үргэлж

Өөрийн санал бодлыг танилцуулж буй баг эсвэл дүр бүтээж буй сурагчид дараах байдлаар үнэлгээ өгч болно. Маш сайн бол 4 оноо, сайн 3 оноо, дунд зэрэг 2 оноо, тааруухан, муу байсан бол 1 оноо өгнө.

Танхим дахь танилцуулга/илтгэл									
Шалгуур	Суралцагчийн үнэлгээ				Багшийн үнэлгээ				
	1	2	3	4	1	2	3	4	
Агуулга: Судалж ойлгосон байдал <ul style="list-style-type: none"> • Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг • Шүүх хуралдаан, түүний дараалал • Шүүх үйл ажиллагааны зарчим 									
– Бие даасан бүтээлч байдал: Өөрийн санаа, дүгнэлт гаргасан – Бүтээлчээр танилцуулсан – Тайлбар хийж, жишээгээр дэлгэрүүлсэн – Үзүүлэн таниулах хэрэгсэл ашигласан									
Танилцуулга/ илтгэх чадвар: <ul style="list-style-type: none"> – Суралцагчдад сонирхолтой байсан – Дуу хоолой тод – Бүлгийн гишүүд бүгд оролцсон – Суралцагчид эерэг үнэлэмжтэй байсан – Оршил үгийг сайн хэлсэн – Үндсэн хэсгээ сайн танилцуулсан – Дүгнэлтийг сайн хийсэн – Өөртөө итгэлтэй байсан 									

Сурагчдын гүйцэтгэлээр нь үнэлсэн тэмдэглэлдээ тулгуурлан “Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулдаг” гэсэн шалгуурыг аль түвшинд хангаж байгааг доорх хүснэгтэд буй мэдээлэлд тулгуурлан тодорхойлох боломжтой юм.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулдаг.	Танилцуулахдаа: -Шүүх үйл ажиллагаанд оролцогч зарим талуудыг нэрлэдэг. -Шүүхийн үйл ажиллагааны талаар нийгмийн орчин тойрноосоо олж сонссон наад захын мэдээллийг давтан хэлдэг.	Танилцуулахдаа: -Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг талаар сурах бичиг болон бусад эх сурвалжаас олж авсан мэдээлэлдээ үндэслэн тайлбар хийхийг оролддог. -Шүүх хуралдааны талаар өнгөц тайлбар хэлдэг.	Танилцуулахдаа: -Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг тухай сурах бичиг болон бусад эх сурвалжаас олж авсан мэдлэгтээ үндэслэн тодорхой тайлбар хэлдэг. -Шүүх хуралдаан, түүний дарааллын талаар боломжит, тохирох тайлбарыг хийдэг.	Танилцуулахдаа: -Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг тухай сурах бичиг болон бусад эх сурвалжаас олж авсан мэдлэгтээ үндэслэн бүрэн зөв, оновчтой тайлбарыг хэлдэг. -Шүүх хуралдаан, түүний дараалал, шүүх үйл ажиллагааны зарчмуудын талаар оновчтой тайлбарыг хэлж, жишээгээр дэлгэрүүлдэг. -Шүүх үйл ажиллагааны загварыг дуурайн дүрийн тоглолтыг оновчтой хийж үзүүлдэг.

2.2.1.1.6 “Улс төр” үнэлгээний нэгжийн шалгуурын хүрээнд суралцахуйн үр дүнд хүрсэнийг харуулах баримт, нотолгоо цуглуулах, түүнийг шинжлэх: 10-р анги

Шалгуур: Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тодорхойлдог.

Үнэлгээний хэлбэр: Явцын үнэлгээ (Хичээлийн явцад болон бие дааж гүйцэтгэх дасгал, даалгавар өгч үнэлнэ.)

Үнэлгээний даалгавар:

Даалгавар. Дараах жишээг уншаад өөрийн итгэл үнэмшил, үзэл бодолд суурилан аль нь ардчиллын үнэт зүйлсэд хамаарах жишээ болохыг тодорхойлно уу?

- Иргэд саналаа нууцаар өгнө. Би ч саналаа нууцаар өгөх эрхтэй.
- Иргэд саналаа өгөхийн тулд газар өмчлөгч байх ёстой.
- Ням надад огт таалагддаггүй. Тиймээс би түүнийг гэртээ оруулахгүй.
- Бат ажил хийх дургүй. Хүн бүр амьдрахын тулд ажиллах учиртай ч Бат ажил хийхгүй байх эрхтэй.
- Баяраа хуульч, Наран багш, Цэцгээ гэрийн ажилтай. Гэвч тэр гурав эрх тэгш.
- Мөнгөтэй баян хүн хүссэн газар байшин худалдаж авч болно.
- Хүмүүс хүссэнээрээ ашиглаж болох адил хэмжээний өмч хөрөнгөтэй байх ёстой.
- Манай сургуулийн онц сурдаг сурагчид дандаа түрүүлж сурах бичиг авдаг байсан учир одоо сүүлд авах ёстой. Энэ бол юмны ээлж ирлээ гэсэн үг.
- Хүмүүс Мөнхөөд яаж ч хандсан тэр хэзээ ч хүч хэрэглэдэггүй.

АЖЛЫН ХУУДАС

1. Өгөгдсөн жишээг уншаад аль нь ардчиллын үнэт зүйлсэд хамаарахыг ялган бичнэ үү?

.....

2. Ялган бичсэн жишээнүүд ардчиллын үнэт зүйлс, тулгуур зарчимтай хэрхэн холбогдож байгааг тодорхойлно уу?

Ялган бичсэн жишээнүүд ардчиллын үнэт зүйлсэд хамааруулах болсон үндэслэл, дүгнэлт	Үлдсэн жишээнүүд нь ардчиллын үнэт зүйлсэд яагаад хамаарахгүй талаарх үндэслэл

3. Дэвшүүлсэн асуудлын хүрээнд ардчиллын үнэт зүйлсэд хамааруулах болсон үндэслэл, гаргасан дүгнэлт тань Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрх, үүрэгтэй хэрхэн холбогдож байгаа талаарх өөрийн үндэслэлийг гаргана уу?

Үндсэн хуулин дахь иргэний эрх, үүрэгтэй хэрхэн холбогдож байна вэ?	Жишээ татаж тайлбарлана уу?

Ажлын хуудсанд ажиллахдаа сурагчид дараах 2 нэмэлт мэдээллийг шинжилнэ.

Нэмэлт мэдээлэл 1: Монгол улсын үндсэн хуулийн 2-р бүлэг

Нэмэлт мэдээлэл 2: Ардчиллын тулгуур үнэт зүйл /онолын мэдээлэл/

Үнэлэх аргачлал: Ялган бичсэн жишээнүүд ардчиллын үнэт зүйлс, тулгуур зарчимтай хэрхэн холбогдож буй байдлыг гарган илэрхийлсэнийг дараах шалгуураар үнэлнэ.

Шалгуур	Суралцахуйн үр дүн хангалтгүй. Анхаарах шаардлагатай.	Цаашид суралцахуй дэмжин ажиллах шаардлагатай	Боломжийн боловч дэмжлэг хэрэгтэй	Сайн
Ардчиллын үнэт зүйлсийг ялгасан байдал	Ангилан тодорхойлж чадаагүй \1\	Заримыг нь ангилан тодорхойлж чадсан \2\	Ангилан тодорхойлж чадсан, үндэслэл дүгнэлт оновчтой бус \3\	Ангилан тодорхойлж чадсан, үндэслэл дүгнэлт оновчтой \4\

Ардчиллын үнэт зүйлсэд хамааруулах болсон үндэслэл, гаргасан дүгнэлтийг Монгол улсын үндсэн хуультай холбон дараах шалгуураар үнэлнэ.

№	Шалгуур	Суралцахуйн үр дүн хангалтгүй. Анхаарах шаардлагатай.	Цаашид суралцахуйг дэмжин ажиллах шаардлагатай	Боломжийн боловч дэмжлэг хэрэгтэй	Сайн
1	Үндсэн хуулийн иргэний эрх, үүрэгтэй холбон хэрхэн холбогдож буй талаар өөрийн дүгнэлтийг гаргасан байдал	Үндсэн хуулин дахь иргэний эрх үүрэгтэй холбон өөрийн дүгнэлтийг илэрхийлэн гаргаж чадаагүй	Үндсэн хуулин дахь иргэний эрх үүрэгтэй холбон өөрийн дүгнэлтийг илэрхийлэн гаргаж чадсан боловч жишээ, тайлбар оновчтой бус	Үндсэн хуулин дахь иргэний эрх үүрэгтэй холбон оновчтойгоор өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн	Үндсэн хуулин дахь иргэний эрх үүрэгтэй холбон оновчтойгоор өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн, жишээ тайлбар оновчтой

Ажлын хуудас 4: Ардчиллын үнэт зүйл гэж юу болох, түүнд юу юу ордог талаар тодорхойлох гэсэн даалгаврын гүйцэтгэлийг дараах шалгуураар үнэлнэ.

№	Шалгуур	Суралцахуйн үр дүн хангалтгүй. Анхаарах шаардлагатай.	Цаашид суралцахуйг дэмжин ажиллах шаардлагатай	Боломжийн боловч дэмжлэг хэрэгтэй	Сайн
1	Ардчиллын үнэт зүйлийг энгийн амьдралын жишээгээр баяжуулан тодорхойлсон байдал	Тодорхойлолтыг гаргахдаа хичээлийн агуулгатай холбон түлхүүр үг хэллэг болон жишээг сонгож хэрэглээгүй. Ойлголтын уялдаа холбоо тодорхой бус, дүгнэлтгүй, гол санаагүй,	Тодорхойлолтыг гаргахдаа хичээлийн агуулгатай холбон түлхүүр үг хэллэг болон жишээг сонгож хэрэглэсэн боловч ойлголтын уялдаа холбоо, гол санааг сайн гаргаж чадаагүй	Тодорхойлолтыг гаргахдаа хичээлийн агуулгатай холбон түлхүүр үг хэллэг болон жишээг оновчтой сонгож хэрэглэсэн. Ойлголтын уялдаа холбоонд гол санааг нь оновчтой гаргаж чадсан,	Тодорхойлолтыг гаргахдаа хичээлийн агуулгатай холбон түлхүүр үг хэллэг болон жишээг оновчтой сонгож хэрэглэсэн. Ойлголтын уялдаа холбоонд гол санааг нь оновчтой гаргаж чадсан, дүгнэлт тодорхой

Сурагчдын гүйцэтгэлээр нь “Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тодорхойлдог.” гэсэн шалгуурыг аль түвшинд хангаж байгааг доорх хүснэгтэд буй мэдээлэлд тулгуурлан тодорхойлох боломжтой юм.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг тодорхойлдог.	Тодорхойлохдоо: -Ардчиллын зарчим, үнэт зүйлсээс зарим нэгийг нь нэрлэдэг. -Монгол улсын үндсэн хуулинд заасан хүний эрх, эрх чөлөө, иргэний үүргээс мэддэгээ нэрлэдэг.	Тодорхойлохдоо: -Ардчиллын зарчим, үнэт зүйлсээс хэд хэдийг тайлбарладаг. -Ардчиллын зарчим, үнэт зүйлс нь үндсэн хуулийн чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг өнгөц тайлбар хийдэг.	Тодорхойлохдоо: -Ардчиллын зарчим, үнэт зүйлсийг нэрлэж, Монгол улсын үндсэн хуулинд хэрхэн баталгаажсан болохыг нотолдог. -Өгөгдсөн жишээ, тохиолдлуудаас аль нь ардчиллын үнэт зүйл болохыг ялгаж, жишээ татан тайбар хийдэг.	Тодорхойлохдоо: -Өгөгдсөн жишээ, тохиолдол нь ардчиллын зарчим, үнэт зүйлстэй нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, үндэслэл гарган оновчтой илэрхийлдэг. -Ардчиллын суурь зарчим, үнэт зүйлс үндсэн хуулинд хэрхэн тусгалаа олсон болохыг тодорхойлдог. -Өгөгдсөн жишээ тохиолдолд суурилан Монгол улсын үндсэн хуулинд заасан хүний эрх, эрх чөлөө хэрхэн хэрэгждэг тухай эргэцүүлж, дүгнэлт гаргадаг.

2.2.2 ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ:

Үр дүнгийн үнэлгээ нь багшлах үйл ажиллагааны тодорхой хугацааны төгсгөлд хийгдэх бөгөөд бүлэг сэдвийн болон улирлын эцэст сурагчид юу мэдсэн, ойлгосон, юу чаддаг, ямар төлөвшил, хандлагатай (ямар үр дүнд хүрсэн) болсон бэ? гэдгийг тодорхойлох үйл ажиллагаа юм. Эцсийн үнэлгээ нь сурагчдын сурлагын хувь, амжилтыг дүнгээр илэрхийлж, тодорхойлоход оршино.

Хичээлийн жилийн төгсгөлд 5 бүлэг агуулгын хүрээнд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх даалгавраа боловсруулахын тулд нэгдсэн блупринт, даалгаврын төлөвлөгөөг боловсруулна. Энэ нь дараах загвараар байж болно.

9-р ангийн Нийгэм судлал хичээлийн блупринт:

№	Ай	Агуулга	Үнэлгээний зорилт						Нийт			
			Мэдлэг ойлголт		Чадвар		Хандлага		Тоо	Оноо	Хувь	
			Д/тоо	Оноо	Д/тоо	Оноо	Д/тоо	Оноо				
1	1	Хувь хүн ба нийгэм	Бид хэрхэн харилцдаг вэ? /бэлэг тэмдгийн тогтолцоо/	1	1	1	1	1	1	3	3	12
	2		Бид хэрхэн харилцан үйлддэг вэ?			1	1	1	1	2	2	8
	3		Зөрчилдөөнийг даван туулах нь			1	1	1	1	2	2	8
	Нийт			1	1	3	3	3	3	7	7	28
2	4	Хувь хүн ба соёл	Үндэстний соёлын бахархал	1	1			1	1	2	2	8
	5		Соёл үнэт зүйлсийн тогтолцоо болох нь /соёлын өв/			1	1			1	1	4
	Нийт			1	1	1	1	1	1	3	3	12
3	6	Хувь хүн ба эдийн засаг	Хөдөлмөрийн зах зээлд нөлөөлөгч хүчин зүйлс	1	1	1	1			2	2	8
	7		Ажилгүйдэл			1	1	1	1	2	2	8
	8		Мөнгө, түүний үүрэг	1	1	1	1			2	2	8
	Нийт			2	2	3	3	1	1	6	6	24
4	9	Хүний эрх ба хууль	Хүний эрхийн ангилал	1	1	1	1	1	1	3	3	12
	10		Хүний эрхийг хангах талаар төрийн хүлээх үүрэг	1	1	1	1			2	2	8
	Нийт			2	2	2	2	1	1	5	5	20

5	11	Нийтийн удирдлага	Төрийн эрх мэдлийн хуваарилалт	1	1	1	1	1	1	3	3	12
	12		Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломж			1	1			1	1	4
	Нийт			1	1	2	2	1	1	4	4	16
Нэгтгэлээр				7	7	11	11	7	7	25	25	100
Эзлэх хувь				28		44		28		100		

“Хувь хүн ба нийтийн удирдлага” бүлгийг үзэж судалсаны дараагаар сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх даалгаврын төлөвлөгөө, блупринтийг дараах хэлбэрээр боловсруулна.

“Хувь хүн ба нийтийн удирдлага” бүлгийн блупринт, даалгаврын төлөвлөгөө

№	Агуулга	Шалгуур	Үнэлгээний зорилт						Нийт		
			Мэдлэг, ойлголт		Чадвар		Хандлага		Тоо	Оноо	Хувь
			Д/тоо	Оноо	Д/тоо	Оноо	Д/тоо	Оноо			
1	Эрх мэдэл, Төрийн эрх мэдлийн хуваарилалт	УИХ, Засгийн газар, шүүх байгууллагыг хэрэгжүүлдэг эрх мэдлээр нь ялгадаг.	2	2	2	2			4	4	27
		“Эрх мэдлийг хэрэгжүүлж буй арга хэлбэр”, “иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох оролцох боломж” гэсэн үзүүлэлтийн хүрээнд ардчилсан ба ардчилсан бус улс төрийн дэглэм дэх үнэт зүйлсийн онцлог ялгааг тодорхойлдог.			1	1	1	2	2	3	13
2	Үндэсний түвшний удирдлага, шийдвэр	Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.	2	2	1	1	1	2	4	5	27
		Шүүх шийдвэрээ хэрхэн гаргадаг болохыг танилцуулдаг.			1	1	1	2	2	3	13

3	Төр ба иргэний харилцаа (Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломж)	Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцооны төрөл, хэлбэр, арга замуудыг тайлбарладаг.	1	1	1	1	1	2	3	4	20
Нэгтгэлээр			5	5	6	6	4	8	15	19	100
Эзлэх хувь			33.3		40		26.7				

Блупринт, төлөвлөгөөний дагуу даалгавар боловсруулж үр дүнгийн үнэлгээг хийнэ. “Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар” гэсэн хэсгээс дэлгэрүүлж харна уу.

2.3 НЭГЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ДААЛГАВАР

2.3.1 ЖИШИГ ДААЛГАВРЫГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ:

9-р ангийн нийгэм судлал хичээлийн сургалтын хөтөлбөр, хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан “Хувь хүн ба нийтийн удирдлага” агуулгын айн хүрээнд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх жишиг даалгаврыг боловсруулав. Багш нар сурагчдаа үнэлэх даалгавраа боловсруулахдаа энэхүү жишиг даалгавраас санаа авч бүтээлчээр баяжуулан хэрэглэх боломжтой.

Хувь хүн ба нийтийн удирдлага бүлгийн төгсгөлд блупринт төлөвлөгөөний дагуу үнэлэх 15 даалгаврыг боловсруулж үнэлнэ. Жишиг болгож “Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг” гэсэн шалгуурын хүрээнд 5 сонгох даалгаврыг харууллаа. Санаа авч, үлдсэн 10 даалгаврыг боловсруулан үр дүнгийн үнэлгээг хийж, хэмжээсжүүлэн шалгуурын гүйцэтгэлийн 4 түвшин, үнэлгээний 8 түвшний алинд хамаарахыг тодорхойлж үнэлнэ. Мөн жишиг болгож дээрх шалгуурын хүрээнд 1 задгай даалгаврыг харууллаа.

2.3.1.1 Сонгох даалгаврын жишээ, хэрэглэх аргачлал

Агуулга: Хувь хүн ба нийтийн удирдлага

Дэд агуулга: Үндэсний түвшний удирдлага, шийдвэр

Үнэлгээний шалгуур: Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.

Үнэлгээний зорилт: Мэдлэг ойлголт

Даалгаврын зорилго. Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны хэлбэрүүдийг тодорхойлох

Даалгавар 1. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь юм. Цэгийн оронд тохирох хариулыг сонгоно уу? [1оноо]

А. Чуулган В. Байнгын хороо С. Түр хороо D. УИХ-ын тамгын газар

Хариултын тайлбар

Хариултын хувилбар	Хариултын тайлбар	Оноо (зөвхөн зөв хариулт 1 оноотой байна.)
А	Чуулган нь Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр.	1
В	Байнгын хороо нь УИХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр юм.	
С	Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын ажлыг хариуцдаг.	

D	Түр хороо-Тухайлсан тодорхой ажлыг зохион байгуулахаар байгуулагддаг.	
---	---	--

Агуулга: Хувь хүн ба нийтийн удирдлага

Дэд агуулга: Үндэсний түвшний удирдлага, шийдвэр

Үнэлгээний шалгуур: Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.

Үнэлгээний зорилт: Мэдлэг ойлголт

Даалгаврын зорилго. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын бүтцийг тодорхойлж чаддаг болох

Даалгавар 2. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг нэрлэнэ үү. [1оноо]

- A. Ерөнхий сайд, УИХ гишүүд, шүүгчдээс бүрдэнэ.
- B. Ерөнхий сайд. УИХ дарга, агентлагаас бүрдэнэ.
- C. Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн тамгын газраас бүрдэнэ.
- D. Ерөнхий сайд болон сайд нарын танхим , яамдаас бүрдэнэ.

Хариултын тайлбар

Хариултын хувилбар	Хариултын тайлбар	Оноо (зөвхөн зөв хариулт 1 оноотой байна.)
A	Засгийн газрыг ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд УИХ гишүүд, шүүгчид засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд багтахгүй	
B	Засгийн газрыг ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд УИХ дарга, агентлаг энэ бүтэц бүрэлдэхүүнд багтахгүй	
C	Засгийн газрыг ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн тамгын газар энэ бүтэц бүрэлдэхүүнд багтахгүй	
D	Засгийн газар нь Ерөнхий сайд болон сайд нарын танхим, яамдаас бүрдэнэ.	1

Агуулга: Хувь хүн ба нийтийн удирдлага

Дэд агуулга: Үндэсний түвшний удирдлага, шийдвэр

Үнэлгээний шалгуур: Үндэсний түвшинд(Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.

Үнэлгээний зорилт: Мэдлэг, ойлголт

Даалгаврын зорилго. Хууль бүтээх үйл явцыг тайлбарлах

Даалгавар 3. Хууль бүтээх үйл явцыг илэрхийлэх дараах үе шатуудаас хамгийн эхэнд нь байх үе шат аль нь вэ? [1оноо]

- A. УИХ чуулганаар хэлэлцэх
- B. Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
- C. Хууль төсөл боловсруулах
- D. Байнгын хороогоор хэлэлцэх

Хариултын хувилбар	Хариултын тайлбар	Оноо (зөвхөн зөв хариулт 1 оноотой байна.)
A	Чуулган нь УИХ-ын зохион байгуулалтын үндсэн хэлбэр бөгөөд төслийн хэлэлцүүлгийг хоёр удаа хийдэг бөгөөд хууль бүтээх үйл явцын хамгийн эхний үе шат биш юм.	
B	Хуулийн төсөл өргөн мэдүүлэх нь хууль санаачлагч боловсруулсан хуулийн төслөө УИХ-ын даргад өргөн барьдаг.	
C	Хууль төсөл боловсруулах нь хууль санаачлагчийн зүгээс иргэд, мэргэжлийн хүмүүс, холбогдох байгууллагаас санал авч боловсруулах бөгөөд хууль бүтээх үйл явцын хамгийн эхний үе шат юм.	1

D	Байнгын хороо нь УИХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр юм. Байнгын хороо нь УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж дүгнэлт гаргадаг	
---	--	--

Агуулга: Хувь хүн ба нийтийн удирдлага

Дэд агуулга: Үндэсний түвшний удирдлага, шийдвэр

Үнэлгээний шалгуур: Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.

Үнэлгээний зорилт: Чадвар

Даалгаврын зорилго: Хууль санаачлах субъектуудыг ялган таних

Даалгавар 4. Монгол улсын Үндсэн хуульд заасан хууль санаачлах эрх эдлэх субъектуудыг бүрэн илэрхийлсэн мөрийг олно уу. [1оноо]

A	Ерөнхийлөгч	УИХ гишүүн	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч
B	УИХ гишүүн	Засгийн газар	Прокурор
C	УИХ гишүүн	Засгийн газар	Ерөнхийлөгч
D	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	Прокурор	УИХ гишүүн

Хариултын тайлбар

Хариултын хувилбар	Хариултын тайлбар	Оноо (зөвхөн зөв хариулт 1 оноотой байна.)
A	Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн хоёр хууль санаачлах эрхтэй хэдий ч Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч хууль санаачилдаггүй	
B	УИХ-ын гишүүн, Засгийн газар нь хууль санаачлах эрхтэй ч Прокурор хууль санаачлах эрхгүй	
C	Үндсэн хуульд зааснаар хууль санаачлах эрхийг УИХ-ын гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч хэрэгжүүлдэг	1
D	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Прокурор хууль санаачлах эрхгүй	

Агуулга: Хувь хүн ба нийтийн удирдлага

Дэд агуулга: Үндэсний түвшний удирдлага, шийдвэр

Үнэлгээний шалгуур: Үндэсний түвшинд(Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.

Үнэлгээний зорилт: Чадвар

Даалгаврын зорилго: Хууль бий болох үе шатуудыг дарааллын дагуу тогтоох, хэлэлцэх

Даалгавар 5. Хууль бий болох үндсэн үе шатуудыг хүснэгтэд үзүүлжээ. Хууль бий болох үе шатыг зөв дараалуулсан мөрийг олоорой. [1оноо]

A.	Хууль санаачлах	Хуулийн төсөл боловсруулах	Хуулийн төсөл өргөн мэдүүлэх	УИХ-ын чуулганаар хэлэлцэх	Хуулийг ёсчлон нийтлэх	Байнгын хороогоор хэлэлцэх
B.	Хууль санаачлах	Хуулийн төсөл өргөн мэдүүлэх	Байнгын хороогоор хэлэлцэх	Хуулийн төсөл боловсруулах	Хуулийг ёсчлон нийтлэх	УИХ-ын чуулганаар хэлэлцэх
C.	Хууль санаачлах	Хуулийн төсөл боловсруулах	Хуулийн төсөл өргөн мэдүүлэх	Байнгын хороогоор хэлэлцэх	УИХ-ын чуулганаар хэлэлцэх	Хуулийг ёсчлон нийтлэх
D.	Хууль санаачлах	Хуулийн төсөл боловсруулах	Хуулийн төсөл өргөн мэдүүлэх	УИХ-ын чуулганаар хэлэлцэх	Байнгын хороогоор хэлэлцэх	Хуулийг ёсчлон нийтлэх

Хариултын тайлбар

Хариултын хувилбар	Хариултын тайлбар	Оноо (зөвхөн зөв хариулт 1 оноотой байна.)
A	Эхний 3 үе шат зөв бусад нь худлаа дараалалтай байна	
B	Эхний 2 үе шатыг зөв бусдыг худал дараалуулсан	
C	Хууль бий болох бүх үе гатыг зөв дараалуулсан байна	1
D	Эхний 3 үеийг зөв дараалуулсан, сүүлийн 3 үе шатыг буруу дараалуулсан	

Багш сурагчид сорил тестийг хэрхэн зөв гүйцэтгэснийг үнэлнэ.

№	Ажиглах сурагчдын нэрс	Үр дүнгийн үнэлгээ								
		1	2	3	4	5	Оноо	Үнэлгээ хувиар	Түвшин	Шалгуурт харгалзах гүйцэтгэлийн түвшин
1	А сурагч	1	1	1	1	1	5	100	VIII	VII-VIII
2	Б сурагч	1	0	1	1	1	4	80	VI	V-VI
3	В сурагч	1	0	0	1	1	3	60	IV	III-IV
4	Г сурагч	1	0	0	0	0	1	20	I	I-II

Сорил тестийн гүйцэтгэлээр нь “Үндэсний түвшинд(Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг” гэсэн шалгуурыг аль түвшинд хангаж байгааг доорх гүйцэтгэлийн түвшинтэй уялдуулан тодорхойлох боломжтой.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг.	Тайлбарлахдаа: -УИХ, Засгийн газар гэж төрийн байгууллага байдгийг санадаг. -УИХ, Засгийн газраас гаргасан зарим шийдвэрийг нэрлэдэг.	Тайлбарлахдаа: -УИХ, Засгийн газар нь Монгол улсын үндсэн хуулинд заасны дагуу ямар эрх мэдлийн байгууллага болохыг хэлдэг. -УИХ, Засгийн газрын түвшинд шийдвэр гаргах үйл явцын зураглал хийн бүдүүвчээр дүрслэн үзүүлж, өнгөц тайлбар хийдэг. -УИХ, Засгийн газраас гаргадаг шийдвэрийн төрлийг нэрлэдэг.	Тайлбарлахдаа: -УИХ, Засгийн газар нь Монгол улсын үндсэн хуулинд заасны дагуу ямар эрх мэдлийн байгууллага болохыг хэлэхийн хамт, тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүний талаар товч тайлбар хийдэг. -УИХ, Засгийн газрын түвшинд шийдвэр гаргах үйл явцын зураглал хийн бүдүүвчээр дүрслэн үзүүлж онцлогийг нь тайлбарладаг. -УИХ, Засгийн газраас гаргадаг шийдвэрийн төрлийг нэрлэж, ялгааг нь хэлдэг.	Тайлбарлахдаа: -УИХ, Засгийн газар нь Монгол улсын үндсэн хуулинд заасны дагуу ямар эрх мэдлийн хамт, тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүний талаар оновчтой тайлбар хийдэг. -УИХ, Засгийн газрын түвшинд шийдвэр гаргах үйл явцын зураглал хийн бүдүүвчээр дүрслэн үзүүлж, тохирох тайлбарыг оновчтой дэлгэрэнгүй хийдэг. -УИХ, Засгийн газраас гаргадаг шийдвэрийн төрлийг нэрлэж, ялгааг нь хэлдэг. -УИХ, Засгийн газраас гаргасан тодорхой шийдвэрийг сонгон авч “төсөлт ажил” хэлбэрээр судлан танилцуулдаг.

C	1	УИХ-аас чанартай, сайн хуулийг батлан гаргах нь хүний эрх, ард олныхоо эрх ашгийг хамгаалах, амьдралд хэрэгжүүлэх сайн талтай	УИХ-аас чанартай сайн хуулийг батлан гаргах нь хүний эрх, ард олныхоо эрх ашгийг хамгаалах, амьдралд хэрэгжүүлэх сайн талтай гэх мэтээр хүүхэд өөрийн үзэл бодлоор зөв хариулан бичсэн бол	2
	2	Сурагчид чанартай, сайн хуулийг батлан гаргасны ач холбогдлыг дутуу тайлбарлан бичсэн	Сурагчид чанартай, сайн хуулийг батлан гаргасны ач холбогдлыг дутуу тайлбарлан бичсэн бол	1
	3	Буруу хариулсан бол		0
	4	Огт хариулаагүй бол		0

Задгай даалгаврыг хэрхэн зөв гүйцэтгэснийг үнэлнэ.

№	Ажиглах сурагчдын нэрс	Үр дүнгийн үнэлгээ						Шалгуурт харгалзах гүйцэтгэлийн түвшин
		Мэдлэг	Чадвар	Хандлага	Оноо	Үнэлгээ хувиар	Түвшин	
		1	2	2				
1	А сурагч	1	2	2	5	100	VIII	VII-VIII
2	Б сурагч	1	2	1	4	80	VI	V-VI
3	В сурагч	1	1	1	3	60	IV	III-IV
4	Г сурагч	1	0	0	1	20	I	I-II

Задгай даалгаврын гүйцэтгэлээр нь “Үндэсний түвшинд (Парламент, засгийн газар) шийдвэр хэрхэн гардаг болохыг тайлбарладаг” гэсэн шалгуурыг аль түвшинд хангаж байгааг гүйцэтгэлийн түвшинтэй уялдуулан тодорхойлох боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-майл: info@eec.mn Вэб: www.eec.mn